ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/124/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2025 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.......... 3-4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл..........5-9

3. Аудитын тайлан..........12

3.1 Ерөнхий зүйл ..........12

3.2 Материаллаг байдал ..........13

3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт..........13

3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..........13

3.5 Өмнөх аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..........14

3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..........14

4. Аудитын илрүүлэлт ..........14

5. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл..........15

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| НА | Нийцлийн аудит |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 261

танай -ны № -т

ДОРНОД АЙМГИЙН ГУРВАНЗАГАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Г.ЦЭЦЭГСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно. Дорнод аймгийн Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 3 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга 70.0 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

011022098

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **143,194,423.00** | **185,989,962.47** |
| **33** | **АВЛАГА** | 24,033,068.00 | 25,113,607.47 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 24,033,068.00 | 25,113,607.47 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 119,161,355.00 | 119,516,355.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 9,770,500.00 | 9,770,500.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 9,770,500.00 | 9,770,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 38,719,855.00 | 39,074,855.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 802,200.00 | 747,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 37,917,655.00 | 38,327,655.00 |
| 35500 | Биологийн хөрөнгө | 1,671,000.00 | 1,671,000.00 |
| 35600 | Мал амьтад | 69,000,000.00 | 69,000,000.00 |
| 36 | **НӨӨЦИЙН БАРАА** | - | 41,360,000.00 |
| 36300 | Тэжээлийн нөөц | - | 41,360,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,004,761,425.31** | **2,115,589,183.65** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,004,761,425.31 | 2,115,589,183.65 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,986,573,686.00 | 2,095,139,183.65 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 543,378,189.21 | 558,378,189.21 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (63,368,892.18) | (92,662,237.26) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 149,865,705.00 | 301,865,705.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (61,305,704.76) | (102,809,482.44) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 204,895,965.00 | 213,885,965.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (78,497,178.12) | (100,460,379.68) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 40,355,505.00 | 40,805,505.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (22,703,391.46) | (25,864,477.22) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 6,140,461.10 | 6,140,461.10 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (4,805,840.80) | (5,112,863.80) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,610,293,622.00 | 1,741,284,838.40 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (357,674,753.99) | (460,312,039.66) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 18,187,739.31 | 20,450,000.00 |
| 39301 | Програм хангамж | 3,597,200.00 | 3,597,200.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,569,516.85) | (2,947,200.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 19,800,000.00 | 19,800,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (2,639,943.84) | - |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,147,955,848.31** | **2,301,579,146.12** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **50,877,488.58** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 50,877,488.58 |
| **413** | **Өглөг** | - | 50,877,488.58 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 9,517,488.58 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 41,360,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 41,360,000.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,147,955,848.31** | **2,250,701,657.54** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,147,955,848.31 | 2,250,701,657.54 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 337,198,534.17 | 337,198,534.17 |
| 51101 | Өмч: - төрийн | 19,800,000.00 | 19,800,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,545,328,926.42 | 1,648,074,735.65 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 847,026,273.73 | 1,545,328,926.42 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 698,302,652.69 | 102,745,809.23 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 245,628,387.72 | 245,628,387.72 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,147,955,848.31** | **2,301,579,146.12** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,410,133,954.00** | **1,294,561,628.15** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **812,190,922.00** | **297,681,216.40** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 812,190,922.00 | 297,681,216.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 180,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 180,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 812,190,922.00 | 297,091,216.40 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 410,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **597,943,032.00** | **996,880,411.75** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,098,532.00 | 101,190,411.75 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,105,532.00 | 34,774,861.75 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 19,993,000.00 | 66,415,550.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 563,844,500.00 | 895,690,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 563,844,500.00 | 890,690,000.00 |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | - | 5,000,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **717,437,801.31** | **1,191,815,818.92** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **701,830,801.31** | **1,189,435,818.92** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 698,399,573.52 | 1,086,088,983.23 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 370,315,469.60 | 578,190,321.25 |
| 210101 | Үндсэн цалин | 243,632,766.05 | 287,652,100.23 |
| 210102 | Нэмэгдэл | 117,458,688.55 | 244,547,849.91 |
| 210104 | Урамшуулал | 9,224,015.00 | 45,990,371.11 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,753,100.00 | 76,775,260.53 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,357,400.00 | 51,850,160.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,401,200.00 | 6,231,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,165,100.00 | 3,115,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,637,300.00 | 3,115,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,192,100.00 | 12,462,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,104,507.15 | 34,605,268.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,777,907.15 | 20,695,188.74 |
| 210302 | Түлш, халаалт | 13,666,600.00 | 12,499,580.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 660,000.00 | 1,410,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 53,197,863.46 | 56,438,607.65 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,420,900.00 | 3,012,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,691,764.30 | 46,105,084.75 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,617,849.16 | 4,142,662.90 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,467,350.00 | 3,178,360.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,133,880.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 3,133,880.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,997,350.00 | 7,395,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,395,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,997,350.00 | 6,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,325,984.00 | 10,044,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,325,984.00 | 10,044,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,011,900.00 | 5,142,325.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,255,900.00 | 4,400,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 382,325.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 350,000.00 | 360,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 406,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 181,559,519.31 | 317,498,200.06 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,833,756.00 | 120,771,742.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 123,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 140,725,763.31 | 196,603,458.06 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,431,227.79 | 103,346,835.69 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 727,700.00 | 63,226,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 25,946,200.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 36,280,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 727,700.00 | 1,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,703,527.79 | 40,120,635.69 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,703,527.79 | 40,120,635.69 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **15,607,000.00** | **2,380,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 15,607,000.00 | 2,380,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 15,607,000.00 | 2,380,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **692,696,152.69** | **102,745,809.23** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **692,696,152.69** | **102,745,809.23** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **597,943,032.00** | **997,060,411.75** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | - | **180,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 180,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 180,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 180,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **597,943,032.00** | **996,880,411.75** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,098,532.00 | 101,190,411.75 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,405,532.00 | 34,774,861.75 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 19,693,000.00 | 66,415,550.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 563,844,500.00 | 895,690,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 563,844,500.00 | 890,690,000.00 |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | - | 5,000,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **572,341,032.00** | **994,680,410.75** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **572,341,032.00** | **994,680,410.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **568,909,804.21** | **891,333,575.06** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 380,315,469.60 | 578,190,320.25 |
| 210101 | Үндсэн цалин | 249,632,766.05 | 287,652,099.23 |
| 210102 | Нэмэгдэл | 121,458,688.55 | 244,547,849.91 |
| 210104 | Урамшуулал | 9,224,015.00 | 45,990,371.11 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,753,100.00 | 77,855,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,357,400.00 | 52,930,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,401,200.00 | 6,231,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,165,100.00 | 3,115,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,637,300.00 | 3,115,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,192,100.00 | 12,462,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,080,527.15 | 44,779,560.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,777,907.15 | 11,177,700.16 |
| 210302 | Түлш, халаалт | 18,642,620.00 | 32,191,360.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 660,000.00 | 1,410,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 41,230,418.46 | 34,491,827.65 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,775,800.00 | 2,639,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 33,959,319.30 | 23,413,304.75 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,617,849.16 | 4,142,662.90 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,877,450.00 | 4,296,360.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,071,250.00 | 13,135,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,073,900.00 | 7,135,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,997,350.00 | 6,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,325,984.00 | 10,044,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,325,984.00 | 10,044,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,761,900.00 | 5,142,325.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,005,900.00 | 4,400,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 382,325.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 350,000.00 | 360,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 406,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 48,371,155.00 | 127,694,742.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,371,155.00 | 127,571,742.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 123,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,431,227.79** | **103,346,835.69** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 727,700.00 | 63,226,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 25,946,200.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 36,280,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 727,700.00 | 1,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,703,527.79 | 40,120,635.69 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,703,527.79 | 40,120,635.69 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **25,602,000.00** | **2,380,001.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **25,602,000.00** | **2,380,001.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **25,602,000.00** | **2,380,001.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 25,602,000.00 | 2,380,001.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 25,602,000.00 | 2,380,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 1.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(25,602,000.00)** | **(2,380,001.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 356,998,534.17 | 245,628,387.72 | 847,026,273.73 | 1,449,653,195.62 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **356,998,534.17** | **245,628,387.72** | **847,026,273.73** | **1,449,653,195.62** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 692,696,152.69 | 692,696,152.69 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **356,998,534.17** | **245,628,387.72** | **1,539,722,426.42** | **2,142,349,348.31** |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **356,998,534.17** | **245,628,387.72** | **1,539,722,426.42** | **2,142,349,348.31** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **356,998,534.17** | **245,628,387.72** | **1,539,722,426.42** | **2,142,349,348.31** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 102,745,809.23 | 102,745,809.23 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **356,998,534.17** | **245,628,387.72** | **1,642,468,235.65** | **2,245,095,157.54** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 896,290,000.00 | 855,749,364.31 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 893,290,000.00 | 853,369,364.31 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 830,063,800.00 | 790,143,164.31 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 610,211,100.00 | 578,190,321.25 |
| 210101 | Үндсэн цалин | 312,584,600.00 | 287,652,100.23 |
| 210102 | Нэмэгдэл | 251,908,700.00 | 244,547,849.91 |
| 210104 | Урамшуулал | 45,717,800.00 | 45,990,371.11 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,986,100.00 | 77,855,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,710,500.00 | 52,930,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,319,000.00 | 6,231,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,159,400.00 | 3,115,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,159,400.00 | 3,115,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,637,800.00 | 12,462,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 45,602,000.00 | 44,779,560.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,800,000.00 | 11,177,700.16 |
| 210302 | Түлш, халаалт | 31,362,000.00 | 32,191,360.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,440,000.00 | 1,410,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 34,257,200.00 | 33,685,087.90 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,712,000.00 | 2,639,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,577,200.00 | 22,606,565.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,960,000.00 | 4,142,662.90 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,008,000.00 | 4,296,360.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,157,700.00 | 7,135,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,157,700.00 | 7,135,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,434,000.00 | 7,434,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,434,000.00 | 7,434,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,215,100.00 | 5,142,325.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 4,400,000.00 | 4,400,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 382,325.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 286,100.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 217,200.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 141,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 360,000.00 | 360,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 210,800.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 40,200,600.00 | 35,921,070.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,022,000.00 | 35,798,070.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 178,600.00 | 123,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 63,226,200.00 | 103,346,835.69 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 63,226,200.00 | 63,226,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,946,200.00 | 25,946,200.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 36,280,000.00 | 36,280,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,000,000.00** | **2,380,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 3,000,000.00 | 2,380,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 3,000,000.00 | 2,380,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 896,290,000.00 | 855,749,364.31 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 895,690,000.00 | 855,569,364.31 |
| | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 863,790,000.00 | 823,669,364.31 |
| 300001 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих /орон нутаг/ | 31,900,000.00 | 31,900,000.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 600,000.00 | 180,000.00 |
| 120010 | Туслах үйл ажиллагааны орлого | 600,000.00 | 180,000.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26 | 21 |
| 620001 | Удирдах ажилтан | 6 | 5 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11 | 8 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 9 | 8 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 34,098,532.00 | 101,190,411.75 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 34,098,532.00 | 101,190,411.75 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 33,905,712.00 | 101,190,411.75 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,000,000.00 | 806,739.75 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,000,000.00 | 806,739.75 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 6,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 6,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 717,984.00 | 2,610,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 717,984.00 | 2,610,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,187,728.00 | 91,773,672.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,187,728.00 | 91,773,672.00 |
| | Урсгал шилжүүлэг | | - |
| | Төвлөрүүлэх шилжүүлэг | 192,820.00 | - |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 34,098,532.00 | 101,190,411.75 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 34,098,532.00 | 101,190,411.75 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,405,532.00 | 34,774,861.75 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 19,693,000.00 | 66,415,550.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 53,541.0 мянган төгрөгийн 5 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

*Залруулсан алдаа:*

- Нийгмийн даатгалын шимтгэлийн 1,080.5 мянган төгрөгийн илүү төлөлтийг авлагын бүртгэл, тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал тусгана, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.
- "ДБЭХС" ТӨХК-д өгөх цахилгааны 9,517.5 мянган төгрөгийн төлбөрийн үлдэгдлийг өр төлбөрийн бүртгэл, тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. 3-т “бүх өр төлбөр”-ийг заавал тусгана, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.
- Хөдөө аж ахуйн газраас хөнгөлөлттэй үнээр ирүүлсэн 80.0 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 517 боодол 41,360.0 мянган төгрөгийн өвсийг хөрөнгийн бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал тусгана, УСНББОУС -17, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.
- "Хүүхэд эрдэнэ" хүүхэд хамгааллын төслийн хүрээнд хүлээн авсан 3 нэр төрлийн 1,100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал тусгана, УСНББОУС -17, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- Худалдан авсан 2 нэр төрлийн 483.0 мянган төгрөгийн камер, картыг бүртгэл, тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал тусгана, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.

Аудитаар нийт 56,120.2 мянган төгрөгийн 7 зөрчил[2] илэрснээс, 3,300.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 28,187.1 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 24,033.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгч ажиллалаа.

### 3.1 Төлбөрийн акт

1. Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдад 3 сарын тэтгэмж 3,900.0 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас олгосон ажилгүйдлийн тэтгэмжтэй давхардуулан олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "..., ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Албан шаардлага

1. Үр дүнгийн урамшууллатай давхардуулан 2,494.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна.
2. Сонгуулийн сурталчилгааны самбар худалдан авахад 0.8 сая төгрөгийг ЗДТГ-ын төсвөөс, 0.8 сая төгрөгийг Засаг даргын нөөцийн сангийн хөрөнгөөс тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” гэж заасныг зөрчсөн байна.
3. Тайлант онд худалдан авсан бичиг хэргийн материалын 1.4 сая төгрөгийг, шатахуун болон нүүрсний 22.7 сая төгрөгийг тус тус шууд зардлаар бүртгэн тайлагнасан байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т ""давхар бичилт" гэж ажил, гүйлгээг дансны дебет, кредитэд зэрэг бичилт хийхийг", 14-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
4. "Маягт, заавар батлах тухай" Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын дагуу анхан шатны баримтыг бүрэн нөхөн хөтлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
5. Шилэн дансны цахим хуудсанд 25 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Илрүүлэлт:* Өмнөх оноос дамжин ирсэн шүүхийн шийдвэртэй холбоотой 2022 онд үүссэн 24,033.1 мянган төгрөгийн авлага байна.

*Өгсөн зөвлөмж*: Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.” гэж заасны дагуу байгууллагыг хохиролгүй болгох.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | То о | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн | То о | Дүн |
| Нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлтийг авлагын бүртгэл, тайланд тусгаагүй | 1 | 1,080.5 | - | - | 1 | 1,080.5 | - | - | - | - | - | - |
| ДБЭХС" ТӨХК-д өгөх цахилгааны төлбөрийн үлдэгдлийг өр төлбөрийн бүртгэл, тайланд тусгаагүй | 1 | 9,517.5 | - | - | 1 | 9,517.5 | - | - | - | - | - | - |
| ХААГ-с хөнгөлөлттэй үнээр ирүүлсэн 80.0 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 517 боодол өвсийг хөрөнгийн бүртгэл тайланд тусгаагүй | 1 | 41,360.0 | 1 | 41,360.0 | -- | - | - | - | - | - | - | - |
| "Хүүхэд эрдэнэ" хүүхэд хамгааллын төслийн хүрээнд хүлээн авсан 3 нэр төрлийн тоног төхөөрөмжийг бүртгэл тайланд тусгаагүй | 1 | 1,100.0 | 1 | 1,100.0 | - | - | - | - | - | - | - | - |
| Худалдан авсан 2 нэр төрлийн камер, картыг бүртгэл, тайланд тусгаагүй | 1 | 483.0 | 1 | 483.0 | -- | | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **5** | **53,541.0** | **3** | **42,943.0** | **2** | **10,598.0** | - | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдад 3 сарын тэтгэмжийг Нийгмийн даатгалын сангаас олгосон ажилгүйдлийн тэтгэмжтэй давхардуулан олгосон | 1 | 3,900.0 | 1 | 3,900.0 | | | | |
| Үр дүнгийн урамшууллатай давхардуулан мөнгөн урамшууллыг олгосон | 1 | 2,494.0 | | | 1 | 2,494,0 | | |
| Сонгуулийн сурталчилгааны самбар худалдан авахад 0.8 сая төгрөгийг ЗДТГ-ын төсвөөс, 0.8 сая төгрөгийг Засаг даргын нөөцийн сангийн хөрөнгөөс зарцуулсан | 1 | 1,600.0 | | | 1 | 1,600.0 | | |
| Тайлант онд худалдан авсан бичиг хэргийн материалын 1.4 сая төгрөгийг, шатахуун болон нүүрсний 22.7 сая төгрөгийг тус тус шууд зардлаар бүртгэн тайлагнасан байна. | 1 | 24,093.1 | | | 1 | 24,093.1 | | |
| Анхан шатны баримтыг бүрэн нөхөн хөтлөөгүй | 1 | 0,0 | | | 1 | 0.0 | | |
| Өмнөх оноос дамжин ирсэн шүүхийн шийдвэртэй холбоотой 2022 онд үүссэн мянган төгрөгийн авлага байна. | 1 | 24,033.1 | | | | | 1 | 24,033.1 |
| **Дүн** | **6** | **56,120.1** | **1** | **3,300.0** | **4** | **28,187.1** | **1** | **24,033.1** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 25 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна | 1 | 0.0 | - | - | 1 | 0.0 | - | - |
| **Дүн** | **1** | **0.0** | - | - | **1** | **0.0** | - | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| **Нийт дүн** | | | | | | | | |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 24 өдөр Дугаар 12/А1160205 Чойбалсан хот

ДОА-2025/124/НА-СТА-Т43

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчид 3 сарын тэтгэмж 3,900.0 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас олгосон ажилгүйдлийн тэтгэмжтэй давхардуулан олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "..., ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "*цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан тооцож олгосон 3,900,000.00 /Гурван сая есөн зуун мянган/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Цэцэгсүрэн, нягтлан бодогч Б.Өсөхбаяр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

2125050030

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр — Дугаар 01/23/ТТ0160505 — Чойбалсан хот

ДОА-2025/124/НА-СТА-ТМУ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 2,494.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Цэцэгсүрэн, нягтлан бодогч Б.Өсөхбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

011041536

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр Дугаар 02/24/А1160305 Чойбалсан хот

ДОА-2025/1124/НА-СОА-ТДЦ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сонгуулийн сурталчилгааны самбар худалдан авахад 0.8 сая төгрөгийг ЗДТГ-ын төсвөөс, 0.8 сая төгрөгийг Засаг даргын нөөцийн сангийн хөрөнгөөс тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6 *дахь ”төсвийг зориулалт бусаар зарцуулсан;”* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллахыг Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Цэцэгсүрэн, нягтлан бодогч Б.Өсөхбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

011041539

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр Дугаар 03/25/А1160305 Чойбалсан хот

ДОА-2025/124/НА-СТА-ПТ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд худалдан авсан бичиг хэргийн материалын 1.4 сая төгрөгийг, шатахуун болон нүүрсний 22.7 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэн тайлагнасан байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т "давхар бичилт" гэж ажил, гүйлгээг дансны дебет, кредитэд зэрэг бичилт хийхийг", 14.-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 *дэх "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтлөх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Нягтлан бодох бүртгэлийг хууль, заавар, аргачлалын дагуу хөтөлж ажиллахыг Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Цэцэгсүрэн, нягтлан бодогч Б.Өсөхбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

011041542

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр Дугаар 04/26 / ДА1160305 Чойбалсан хот

ДОА-2025/124/НА-СОА-ТИ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Маягт, заавар батлах тухай" Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын дагуу анхан шатны баримтыг бүрэн нөхөн хөтлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 дэх *"нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтыг батлагдсан маягтын дагуу хөтлөх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг баримтлан ажиллахыг Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Цэцэгсүрэн, нягтлан бодогч Б.Өсөхбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

011041545

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр Дугаар 05/27/А1160305 Чойбалсан хот
ДОА-2025/124/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 25 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. *Тухайлбал:*

1.Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл 11 сар бүр
2.Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангиллыг 11 сар бүр
3. Байгууллагын батлагдсан төсөв
4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
5. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 *дэх ” хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.;”* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулж байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Цэцэгсүрэн, нягтлан бодогч Б.Өсөхбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

2125040003